

Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийн
шинэчилсэн найруулга батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 73 дугаар зүйлийн 73.7 дахь хэсэг, 2019 оны 11 сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Сүхбаатар/-д даалгасугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 8 сарын 2-ны өдрийн 2018/12 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2019 оны 11 сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын саналын хуудсыг 2019 оны 10 сарын 1-ний өдрөөс 11 сарын 11-ний өдрийг хүртэл Ард Кредит ББСБ ХК-ийн төв оффис болох Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Холдингсын байр, 2 давхар хаягаар болон ardcredit.shareholdersmeeting@gmail.com цахим шуудангийн хаягаар тус тус хүлээн авав.

Эчнээ санал хураалтад оролцсон хувьцаа эзэмшигчид: 87.32%

Тооллогын комиссын дарга Б.Мөнхзул дүгнэлт хийснээр: Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд нийт саналын эрхтэй 244,498,406 ширхэг хувьцаа буюу 87.32%-ийн хувьцаа эзэмшиж байгаа 52 хувьцаа эзэмшигч оролцож, Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.7 дахь хэсэгт заасны дагуу эчнээ санал хураалт, дүрмийн 7 дугаар зүйлийн 7.13-ыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтыг хүчин төгөлдөрт тооцов.

Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлах;

Хэлэлцсэн нь №1: Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлах тухай.

Санал хураалтыг 2019 оны 10 сарын 1-ний өдрөөс 11 сарын 11-ний өдөр хүртэл явуулав.

Тооллогын комиссын дарга Б.Мөнхзул: Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

Тооллогын комиссын шийдвэр:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлах асуудлаар.

Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлах тухай санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 244,498,406 ширхэг санал;

Татгалзсан: 0 ширхэг санал;

Түдгэлзсэн: 0 ширхэг санал тус тус ирсэн байна.

Дээрх санал хураалтын дүнг үндэслэн Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлав.


Эчнээ санал хураалтад оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 3,818,780 ширхэг хувьцаа эзэмшиж буй нийт 5 хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

Эчнээ санал хураалтын шийдвэр:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Ганхуяг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:


Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлав.

ХЯНАСАН:
ТУЗ-ийн дарга



Ч.Ганхуяг

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
Төлөөлөн удирдах зөвлөлийн
нарийн бичгийн дарга



М.Мөнхсүрэн